ЦАХИМ ЗАЛИЛАНГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

“ЭРХ ЗҮЙН ОРОЛЦООТ ТӨГӨЛДӨРШИЛ” НҮТББ

2026 ОН
УЛААНБААТАР ХОТ

Товъёг

Үнэлгээний үндсэн дүгнэлт....3

Нэг. Үнэлгээний зорилго хүрээ арга зүй....3

Хоёр. Шалгуур ба үнэлэх хэсэг....5

Гурав. Зорилгод хүрэх байдлын үнэлгээ....5

Дөрөв. Практикт хэрэгжих боломж....7

Тав. Ойлгомжтой байдлын үнэлгээ....9

Зургаа. Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээ....10

Долоо. Хүний эрхэд нөлөөлөх байдал....11

Найм. Харилцан уялдаа....13

Ес. Зөвлөмж....16

Үнэлгээний гол дүгнэлт

Төсөл цахим залилангийн тухай шуурхай мэдэгдлийг эрүүгийн хэрэг нээхийг хүлээлгүй хүлээн авах, мөнгө цааш шилжихээс сэргийлэх богино хугацааны хамгаалалт хэрэгжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийн үүргийн зөрчлөөс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх гэсэн уялдаатай механизм бүрдүүлэхээр байна. Эдгээр нь хохирогчийн эрхийг бодитоор хамгаалах боломжтой механизм юм.

Шалгуур	Үнэлгээний үр дүн
Зорилгод хүрэх байдал	Хөрөнгө хамгаалах, тусламж авах механизмыг дэмжинэ. Буцаалт ба нөхөн төлбөрийн ялгааг хадгална.
Практикт хэрэгжих боломж	Ээлжийн хүчин чадал, 30 минутын хариу, дөрвөн цагийн дахин хяналтыг практикийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн илүү боловсронгуй болгох.
Ойлгомжтой байдал	Дугаарлалтыг нятглах, байхгүй заалтын эшлэл байгааг засах.
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Баримт бичгээс тогтоох боломжгүй.
Зардал	Одоо байгаа нөөцөд тулгуурласан хувилбар боломжтой.
Харилцан уялдаа ба хүний эрх	Өмчлөх эрх, хувийн мэдээлэл, үзэл бодол, гомдлын хамгаалалтыг тусгасан.

Нэн түрүүнд 23–26, 29, 34, 46–47, 67 дугаар зүйлийн эшлэлийг засах; 17.6 дахь хадгалалтын хүрээг ялгах; 15.3, 32.4 дэх тасралтгүй ажиллагааг эрсдэлд тохирсон зохион байгуулалттай уялдуулах; 69–71 дүгээр зүйлийн хэрэгжилтийг зураглалтай болгох шаардлагатай.

Нэг.Үнэлгээний зорилго, хүрээ, арга зүй

1.1. Үнэлгээний объект ба эрх зүйн үндэслэл

Үнэлгээг “Цахим залилангаас урьдчилан сэргийлэх, хохирогчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийн 11 бүлэг, 72 зүйлтэй эхэд хийв.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17.2-т заасан шалгуур сонгох, үнэлэх хэсгийг тогтоох, үр нөлөөг тооцох, үр дүнг үнэлж зөвлөмж өгөх дараалыг баримтлав. Хүний эрхийн нөлөөг 17.2.4, эрхийн хязгаарлалтыг 17.3 дахь зайлшгүй шаардлага, ялгаварлан гадуурхахгүй байх, зорилгод тохирсон хамгийн бага хязгаарлалтын шаардлагаар нэмэлтээр шалгав. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын зургаан шалгуурыг ашигласан болно.

1.2. Хэрэглэсэн арга ба нотолгооны хязгаар

Хуулийн заалтыг зорилготой нь тулгасан логик шинжилгээ, холбогдох хуулийн эрх хэмжээ ба процессын харьцуулалт, төслийн дотоод эшлэлийн шалгалт, зохиомол нөхцөлөөр ажиллагааны дараалал шалгах арга, тусдаа зардлын загварыг хэрэглэлээ. Зохиомол нөхцөлийн шалгалт нь бодит банк, оператор дээр гүйцэтгэсэн туршилт биш бөгөөд аргачлалын 4.6-д заасан практик туршилт эсхүл байгууллагын санал авах ажиллагаанд хамаарахгүй болно.

Ойлгомжтой байдлыг эрх зүйн найруулга, хугацаа, эрх ба үүргийн тодорхой байдлаар шалгалаа. Хэрэглэгчийн ойлголтын сорил, оролцогчийн санал асуулгын үр дүн байхгүй тул эдгээрийг дүгнэх боломжгүй. Харин ямар асуултыг хэнээр, ямар баримтаар баталгаажуулахыг тусгайлан тогтоов.

Хоёр. Шалгуур ба үнэлэх хэсэг

Шалгуур ба сонгосон шалтгаан	Үнэлэх заалт	Шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал: Шуурхай хамгаалалт хохирлыг бууруулах холбоотой эсэх	1, 3, 15–29, 35–56, 60–65	Зорилго ба механизмын логик шинжилгээ
Практикт хэрэгжих боломж: Хугацаатай үүрэг, шинэ чиг үүрэг нэмэгдэж байгаа	6–21, 23–34, 40, 43–56, 58, 62–72	Ажиллагааны загвар
Ойлгомжтой байдал: Алдаатай ойлголт эрхийг шууд хязгаарлана	3–4, 17, 23–29, 34–40, 46–49, 57–61, 67	Эшлэл, дугаарлалт, нэр томьёо ба хугацааны шалгалт
Хүлээн зөвшөөрөгдөх байдал: Олон салбарын үүрэг, хариуцлага нэмэгдэнэ	11–14, 23–34, 43–61	Оролцогчийн ашиг сонирхлын шинжилгээ; санал авах асуулт
Зардал: Иргэн, төр, үйлчилгээ үзүүлэгчийн нэмэгдэл ажил	6–21, 22–56, 58–70, 72	59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын тусдаа тооцоо
Харилцан уялдаа: Давхардал, хийдэл, эрхийн хязгаарлалт	Төслийн бүх 1–72 дугаар зүйл	Аргачлалын 4.10 дахь 16 асуулт; хүний эрхийн нэмэлт шалгалт

Гурав.Зорилгод хүрэх байдлын үнэлгээ

3.1. Мэдэгдлээс хамгаалалтад чиглэсэн арга хэмжээ

3.7, 22.2, 32.4.6-д баримт дутуу, эрүүгийн хэрэг үүсээгүй, хохирогчоор тогтоогоогүйг шуурхай шалгалтаас татгалзах үндэслэл болгохгүй гэж заасан нь зорилгод нийцэж байна. Хохирогчийн мэдээллийг анх хүлээн авах болон хөрөнгийг буцаах эрхийг нотлох ажиллагааг ялгасан нь мөнгө цааш шилжихээс өмнө эрсдэлийг шалгах боломж олгож байна. Эдгээр заалтыг хадгалах нь зүйтэй.

Гэхдээ 3.5 дахь хэсгийг “цахим залилангийн шинжгүй, зөвхөн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргаан”-д хамаарахаар тодруулах шаардлагатай.

3.2. Хөрөнгө хамгаалах ба буцаан олгох

24 дүгээр зүйл гүйцэтгээгүй гүйлгээг саатуулах, 25 дугаар зүйл хүлээн авсан хөрөнгийн зарцуулалтыг хязгаарлах өөр ажиллагааг зохицуулжээ. 25.2-т холбогдох гүйлгээ болон мөрөөр тогтоосон үлдэгдлийн аль бага дүнгээр хязгаарлах, хамааралгүй ирээдүйн орлогыг автоматаар хамруулахгүй байх нь хохирогчийг хамгаалах болон гуравдагч этгээдийн өмчийг хүндэтгэх зорилгыг зэрэг хангахад ач холбогдолтой.

23.4–23.6 дахь хугацааны эхлэл, дуусмагц цуцлах, цааш үргэлжлүүлэхэд өөр хуулийн хүчинтэй шийдвэр шаардах зохицуулалт нь оновчтой байна. 27.6, 29.3-т буцаалтын шалгалтын хугацаа нь хязгаарлалтыг сунгахгүй гэж тусгасан нь мөн оновчтой зөв зохицуулалт болжээ.

28.1-ийн зөвшөөрөл эсхүл эрх бүхий шийдвэрт үндэслэн хөрөнгө шилжүүлэх нөхцөл нь банк өмчлөх эрхийн маргааныг өөрөө эцэслэн шийдэхээс сэргийлэх байгаа боловч маргаантай хэсгийг процессын журмаар хамгаалах хүсэлтийг хэнд, ямар баримтаар хүргүүлэхийг ажиллагааны зааварт тодруулах шаардлагатай.

3.3. Урьдчилан сэргийлэх үүргийн үр нөлөө

35–38 дугаар зүйлд баталгаажуулалт, эрсдэлд тохирсон анхааруулга, нэр ба дансны нийцлийн шалгалтыг тусгажээ. Эдгээр нь хэрэглэгч зөвшөөрсөн боловч хууртагдсан шилжүүлгийг илрүүлэхэд чиглэж байна. 4.2, 32.3 дахь хэсэг нэг удаагийн код ашигласан нь залилан байхгүйг данган нотлохгүй гэсэн зарчим үүргийн хариуцлагыг бүхэлд нь хэрэглэгчид шилжүүлэхээс сэргийлж байгаа нь давуу талтай. Нэр данс таарсан нь залилан байхгүй гэсэн баталгаа биш гэдгийг 35.1.11-д хадгалсан нь ач холбогдолтой.

44–48 дугаар зүйл утасны дугаар, зурвас, хэрэглэгчийн бүртгэлээр хуурах боломжийг бууруулж байгаа нь эерэг юм. 52–53 дугаар зүйл зар захиалагч ба санхүүгийн зөвшөөрлийг шалгах үүрэгтэй ба эдгээрийн үр нөлөө зөвхөн зар, дуудлага хаасан тоогоор хэмжигдэхгүй; хууль ёсны үйлчилгээ буруу хаагдах, өөр суваг руу залилан шилжих, шинэ хэрэглэгч бүртгүүлэхэд саад нэмэгдэх эрсдэлийг хамт хэмжих шаардлагатай.

3.4. Хохирлын төлбөр ба туслалцаа

60.1–60.3 дахь хэсэг нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийн зөрчил, шалтгаант холбоотой хохирлыг хариуцуулах зарчимд тулгуурлажээ. Залилан бүрийг банкаар автоматаар төлүүлэх тогтолцоо биш гэдэг нь мэдээж хэдий ч энэ ялгааг хэрэглэгчид тайлбарлахгүй бол хууль буцаан төлөлтийг бүх тохиолдолд баталгаажуулсан мэт хүлээлт үүсэж болзошгүй тул хууль батлагдсаны дараа сурталчлан таниулах ажлыг сайн зохион байгуулах нь зүйтэй. 61.2-ын давхар төлөлтөөс сэргийлэх, 61.5-ын эрхээс урьдчилан татгалзуулахгүй байх хамгаалалт тусгагдсан нь үр дүнтэй.

Залилангийн мэдээллийг хаана, хэр хурдан өгөхийг мэдсэн эсэх, баримтаа хадгалж чадсан эсэх, хариуцсан ажилтантай холбогдсон эсэхээр үр дүнг хэмжих нь зорилготой илүү нийцнэ.

Дөрөв.Практикт хэрэгжих боломж

4.1. Байгууллагын үүрэг ба хүчин чадал

6–14 дүгээр зүйлээр цагдаагийн байгууллага мэдээллийн урсгалыг уялдуулах, салбарын зохицуулах байгууллага өөрийн харьяалалд хяналт тавих, ХЭҮК хүний эрхийн хяналт хийхээр ялгасан нь шинэ байгууллага байгуулахгүйгээр хэрэгжүүлэх суурь зохицуулалт агуулсан байна. Цагдаагийн байгууллагын өмнөх шуурхай ажиллагаа буюу хариу арга хэмжээний туршлага нь байгууллага хооронд залилангийн хохирлыг бууруулах ажиллагаа бодитоор боломжтойг харуулж байна.

10.3.10 дахь 23.7 гэсэн эшлэл нь урт хугацааны процессын шийдвэр бус, хэрэглэгчийн хүсэлтийг дахин хянах хэсэгт хүргэж байх тул үүнийг 23.6 болгож засахгүй бол шуурхай нэгж хэний ямар шийдвэрийг бүртгэх талаар зөрүү үүснэ. 38.4.2 дахь өөрийн эрх бүхий ажилтны шийдвэрийг үйлчилгээ үзүүлэгчид дахин мэдэгдэх найруулгыг 23.1-д нийцүүлэн, дотоод гүйцэтгэх нэгжид хүргүүлэх байдлаар тодруулах эсэхийг нягтлах нь зүйтэй.

15.3, 32.4-ийн хоногийн турш ажиллагааг нэг ажилтан томилсноор хангахгүй. Анхны шийдвэр гаргаагүй ажилтан дөрвөн цагийн дотор дахин хянах ёстой тул орлох ажилтан, эрхийн тохиргооны зохицуулалт хэрэгтэй. Том байгууллагын бэлэн ээлжийг ашиглаж болох ч жижиг этгээдийн боломжийг тусад нь шалгана.

4.2. Ажиллагааны нөхцөлөөр хийсэн шалгалт

Дараах жишээ нь хуулийн төслийн логик дарааллыг шалгах зорилготой хийсэн зохиомол нөхцөлүүд юм. Үүнд:

Жишээ нөхцөл	Хуулийн төсөлд тусгагдсан ажиллагаа	Илэрсэн асуудал ба шийдэл
Баасан гарагийн шөнө хууртагдсан шилжүүлэг мэдэгдэх	22, 25, 40; амралтын өдрийг хүлээлгүй шалгах	7/24 цаг . Ээлж ба эрх бүхий орлох ажилтныг шалгана.
Гүйлгээ гурван банкаар дамжсан	26.1–26.4; үлдэгдлийг тулган шийдвэрлэх	Нэг хохирлыг гурван удаа бүх дүнгээр хязгаарлахгүй. Нэгдсэн дугаарын олгохын уялдаа хангагдана.
24 цаг дуусахад мөрдөгчийн хүчинтэй шийдвэр ирээгүй	23.5–23.6, 25.5; хязгаарлалтыг цуцлах	Дотоод шалгалт дуусаагүй гэх үндэслэлээр сунгахгүй. Хугацааны автомат сануулга, хүний хяналт хэрэгтэй.
Данс эзэмшигч хууль ёсны цалингаа авч чадахгүй болсон	25.2, 23.7; хамааралгүй хөрөнгийг чөлөөлөх	Холилдсон мөнгийг мөрөөр нь ялгах нотолгоо, дөрвөн цагийн дахин хяналтыг шалгана.
Олон хохирогч нэг үлдэгдэл шаардах	29; эрх ба дараалал шалгаж санал гаргах	Банкны санал нь шилжүүлэх шийдвэр биш. Давхар 29.5 ба байхгүй 28.5–28.6-г засна.
Залилан гэж олноор мэдээлсэн шүүмжлэлт нийтлэл	55.4, 56; агуулгын бодит шинж шалгах	Мэдэгдлийн тоогоор хаахгүй. Нийт домэйн, бусад хууль ёсны агуулгыг хамгаална.
Гадаад платформ хариу өгөхгүй байх	16, 54; баталгаатай хүргэлт, эрх бүхий хамтын ажиллагаа	Монголын шийдвэр гадаадад шууд үйлчлэхгүй.
Мэдээллийн систем тасалдах	15.2, 20, 31.2.6; нөөц суваг	Баталгаажуулалт, бүртгэлтэй нөөц сувгийг урьдчилан шалгана.

4.3. Хугацаа ба техникийн боломж

40.3-ын эхний өгүүлбэрт хүлээн авсны баталгааг 30 минутын дотор хүргэх, дараагийн өгүүлбэрт эхний хариуг 30 минутын дотор өгөхөөр заажээ. Хоёр дахь хугацааг баталгаа явуулснаас шинээр тоолох эсэх нь тодорхой бус байна. Хүлээн авсан нэг мөчөөс хоёр үүргийн хугацааг тоолох эсэхийг хуульд тодорхой болгох шаардлагатай.

35.1.9–35.2 дахь нэр данс тулгах, 46 дугаар зүйлийн дуудлагын эх үүсвэр шалгах, 53.3 дахь зөвшөөрлийн бүртгэлтэй тулгах үүрэг нь нэг байгууллагын дотоод журамтай адил биш бөгөөд мэдээллийн формат, хариуны төлөв, галиг ба нэрийн зөрүү, тасалдал, алдаа залруулах техникийн нийтлэг нөхцөл шаарддаг. Одоо байгаа систем хангаж буй хэсгийг тогтоож, зөвхөн дутуу функцийг хөгжүүлэх нь хэрэгжих боломж, зардлын аль алинд ач холбогдолтойг анхаарах нь зүйтэй.

Виртуал хөрөнгийн 43.4.5–43.4.8-д үйлчилгээ үзүүлэгчийн бодит хяналтад байгаа хөрөнгийг хамгаалах, хяналтаас гарсан бол мөр, баримтыг хадгалж мэдээлэхээр ялгасан нь хэрэгжих боломжид нийцэж байна.

Тав. Ойлгомжтой байдлын үнэлгээ

Заалт	Илэрсэн асуудал	Засах чиглэл
7.1.5, 8.1.4	67.3 дахь нэгдсэн тайлан, хугацаа гэж эшилсэн	Нэгдсэн тайланг Засгийн газарт танилцуулах 67.4-тэй нийцүүлэх.
8.2	Үзүүлэлтийг 34.6-аас авсан	Үзүүлэлт жагсаасан 34.5 гэж засах.
10.3.10	Шийдвэрийг 23.7-оос эшилсэн	Хязгаарлалтыг үргэлжлүүлэх шийдвэрийн 23.6 гэж засах.
24.1, 26.1	Хязгаарлах үндэслэлийг 23.3 гэжээ	Бодит үндэслэл, эрсдэлийг тогтоох 23.2 гэж засах.
24.2.2	Мэдэгдэх журмыг 23.4 гэжээ	23.3 гэж засах.
24.2.3	Хугацаа тоолох журмыг 23.5 гэжээ	23.4 гэж засах.
25.6	Дахин хянах журмыг 23.8 гэжээ	23.7 гэж засах.
25, 39 дүгээр зүйл	25.4, 39.5 гэсэн дугаар алгассан	Хассан агуулга байгаа эсэхийг тулгаж, дугаарлалт ба бүх эшлэлийг нэг мөр шинэчлэх.
29 дүгээр зүйл	29.5 гэсэн хоёр өөр хэсэг байна	Дараагийн хэсгүүдийг дараалуулж дугаарлана; зөвшөөрөл ба саналын ялгааг хадгалах.
29.6	28.4–28.6 гэж эшилсэн; 28.5, 28.6 байхгүй	Маргаанд 28.4, шилжүүлэх үндэслэлд 28.1–28.3-ыг зориулалтаар нь эшлэх.
34.6	Тайлан ирүүлэх хэсэг	Үйлчилгээ үзүүлэгчийн тайлангийн 34.5 гэж засах.
11.3.6, 12.2.8, 67.1	Үйлчилгээ үзүүлэгчийн тайланг 34.6 гэж эшилсэн	34.5 дахь тайлан ба 67.1 дэх нэгтгэх үүргийг ялган засах.
46.5	Дахин хянах хугацааг 49.6 гэжээ	Дөрвөн цагийн 49.5; сэргээх ажиллагаанд 49.6-г тусад нь эшлэх.
47.2	Байхгүй 46.6-г эшилсэн	49.5, 49.6 дахь дахин хянах ба сэргээх журмыг шууд эшлэх.
67.4	Байхгүй 8.3 болон үзүүлэлтгүй 34.6-г эшилсэн	8.2, 34.5 дахь үзүүлэлттэй уялдуулж найруулах.

36.1-д “мэдэх мэдээлэл, төхөөрөмж, ... биеийн давтагдашгүй шинжээс гадна” бие даасан хоёр хүчин зүйл гэж бичсэн нь эдгээр гурван ангиллаас өөр хоёр хүчин зүйл шаардаж байгаа мэт ойлгогдоно. Мэдэх, эзэмших, биеийн шинжийн ангилалд хамаарах хоорондоо хараат бус хоёроос доошгүй хүчин зүйлд тулгуурлах гэсэн утгыг илэрхий болгож, 35.1.5 дахь биометрик ашиглахгүй хувилбартай нийцүүлэх.

4.1.15 дахь “шалгалтаар тогтоогдсон” гэсэн ойлголт нь үйлчилгээ үзүүлэгчийн эрсдэлийн шалгалт уу, эрүүгийн хэрэгт гэм буруу тогтоосон шийдвэр үү гэдгийг ялгах хэрэгтэй. 3.14, 3.16-д заасан заагийг тодруулж, дансны бүртгэлийн төлөв нь гэм бурууг тогтоосон дүгнэлт биш гэдгийг хэрэглэгчийн тайлбар болон маягтад илэрхий болгох.

60.5-ын “хэт болгоомжгүй”, 68.3-ын “хэтэрхий болгоомжгүй” гэсэн нэршлийг нэг мөр болгох шаардлагатай. Нууц үг, код өгсөн эсхүл анхааруулга дээр дарсан үйлдлийг дангаар нь энэ босго хангасан гэж үзэхгүй; тухайн хүн эрсдэлийг ойлгох бодит боломж, үйлдлийн шалтгаант нөлөө, үйлчилгээ үзүүлэгчийн өөрийн

зөрчлийг хамтад нь үнэлэх. Хуулийн найруулгын энэ тодруулга нь 32.3, 60.6-тай нийцнэ.

Зургаа. Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээ

Оролцогч	Баталгаажуулах гол асуудал	Санал авах баримт
Хохирогч ба хэрэглэгч	Код ашигласан тохиолдолд эрхтэйгээ ойлгох эсэх; баримт дутуу үед мэдээлж чадах эсэх	Хүсэлт, хариуны маягтаар ойлголтын сорил
Буруу хязгаарлагдсан этгээд	Холбогдох хөрөнгийн дүн, шалтгаан, хугацаа, гомдлын суваг ойлгомжтой эсэх	Данс ба агуулга хязгаарлах мэдэгдлийн сорил
Банк ба төлбөрийн үйлчилгээ	30 минут, дөрвөн цаг, 24 цагийн бодит хүчин чадал; нэр данс тулгах боломж	Ээлжийн зураглал, системийн туршилтын бүртгэл
Жижиг үйлчилгээ үзүүлэгч	Хамтарсан хүлээн авах суваг, эрх бүхий ажилтны бэлэн байдал, зардал	Нэгж ажил
Оператор ба платформ	Шалгах дохионы чанар; хууль ёсны агуулгыг хэт хаахгүй байх	Алдаатай дохио, сэргээх ажиллагааны нөхцөлөөр шалгалт
ХЭҮК ба иргэний нийгэм	Мэдээллийн хүрээ, хадгалалт, автомат үнэлгээ, эмзэг бүлгийн хамгаалалт	Эрхийн нөлөөллийг харгалзах

Долоо Хүний эрхэд нөлөөлөх байдал

7.1. Хуулийн 17 дугаар зүйлийн нэмэлт шалгалт

Хуулийн төсөл өмчлөх эрх, хувийн мэдээлэл, мэдээлэл түгээх эрх, шударга ажиллагаа, үр нөлөөтэй гомдол гаргах боломжийг хамарсан байх бөгөөд Үндсэн хуулийн 16 дугаар зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын холбогдох заалттай тулган үзэв. Үүнд:

Арга хэмжээ	Зайлшгүй шаардлага ба бага хязгаарлалт	Хамгаалалт ба нэмж тодруулах зүйл
Мөнгөний зарцуулалтыг 24 цаг хязгаарлах	Хөрөнгө цааш гарах бодит эрсдэл, тухайн гүйлгээний холбоог шалгана	23–25-ын дүн ба хугацааны хязгаарыг хадгална;
Утасны үйлчилгээ хязгаарлах	Зөвхөн залиланд ашигласан үйлдэл; дугаар хуурамчаар харуулсан гэдгээр жинхэнэ эзэмшигчийг хаахгүй	49.3-ын яаралтай тусламжийн боломж; 49.5-ын дахин хяналт.
Агуулгын тархалт хязгаарлах	Шалгасан залилангийн тодорхой агуулга;	55.4, 56.4
Автомат эрсдэлийн үнэлгээ	Хүний шийдвэрт туслах; дангаар эрх хязгаарлахгүй	19.2–19.4, 31.4-ийн хүний хяналт ба алдаа засах механизмыг хадгална.

7.2. Өмчлөх эрх ба үр нөлөөтэй гомдол

23.2-ын бодит үндэслэл, 25.2-ын хамгийн бага дүн, 23.3-ын мэдэгдэл, 23.7-ын хараат бус дотоод дахин хяналт нь өмчлөх эрхийн хязгаарлалтыг тэнцвэржүүлэх гол хамгаалалт болж байна.

7.3.Хувийн мэдээлэл ба нэр төр, алдар хүнд

17.2-ын мэдээллийн сан нь олон салбарын эмзэг мэдээллийг холбох боломжтой тул 17.4-ийн шалгалтын төлөв, 19 дүгээр зүйлийн хүний хяналт, 21 дүгээр зүйлийн мэдээллийн эзний эрх ач холбогдолтой юм.

17.6-д ажиллагаа дууссанаас хойш таван жил хадгалах баримтыг заасан ч батлагдаагүй дохио, буруу мэдээлэл, идэвхтэй хязгаарлалтын төлөв болон нотолгооны бүртгэлийн хадгалалтыг хангалттай ялгаагүй байгааг анхаарах нь зүйтэй.

7.4. Ялгаварлан гадуурхахгүй байх ба хүртээмж

38.2-т нас, оршин суугаа газрыг дангаар нь сэжигтэй тохиодлын үндэслэл болгохгүй гэсэн хамгаалалт байгаа нь зөв зүйтэй. 35.1.5-ын биометрикийн өөр хувилбар, 32.4.2-ын нэвтрэх эрх шаардахгүй мэдээлэх боломж, 63 дугаар зүйлийн хүртээмжийг тусгасан нь оновчтой болжээ.

Найм. Харилцан уялдаа

8.1. Хүчин төгөлдөр хуультай уялдах асуудал

Холбогдох зохицуулалт	Төслийн зааг ба шаардлага
Эрүүгийн хууль ба эрүүгийн процесс	3.8–3.9, 3.14–3.16-ийн зааг. 23.6.1 нь процессын хязгаарлалт руу шилжих бөгөөд үйлчилгээ үзүүлэгчийн шалгалт нь гэм буруу тогтоохгүй хэмээсэн нь нийцэж байна.
Мөнгө угаахтай тэмцэх хууль, 11 дүгээр зүйл	13.2, 23.6.2-ын тусдаа үндэслэл, шийдвэр, хугацааг бүртгэнэ. Залилангийн дохио бүрийг СМА-ны түдгэлзүүлэлтийн үндэслэл гэж үзэхгүй байхаар тусгасан.
Банк ба төлбөрийн зохицуулалт	Нууц мэдээлэл солилцох, буцаан шилжүүлэх үндэслэлийг 15–18, 24, 28, 35, 41-тэй тулгаж дагалдах өөрчлөлтийн жагсаалт гаргана.
Иргэний эрх зүй	28–29-ийн өмчлөл ба шаардах эрх; 60–61-ийн гэм хор, шалтгаант холбоо, хамтын хариуцлага, давхар төлөлтийн тооцоо уялдсан.
Харилцаа холбооны зохицуулалт	44–49-ийн хязгаарлах үндэслэл ба сэргээх үүрэг нь хэрэглэгчийн эрх, салбарын эрх хэмжээтэй нийцсэн байна.
Захиргааны ба иргэний процесс	57–59-д хувийн шийдвэр, захиргааны акт, мөрдөн шалгах шийдвэрийг ялгаж тодруулсан.

8.2. Аргачлалын 4.10 дахь асуултаар хийсэн шалгалт

Асуулт	Дүгнэлт	Үндэслэл ба авах арга хэмжээ
1 Зорилготой нийцэх	Нийцэх суурьтай	Шуурхай мэдэгдэл, хөрөнгө хамгаалалт, буцаалт, тусламжийн холбоо бий.
2 Хууль тогтоомжийн нэр	Нийцнэ	Нийцэл хангагдсан.
3 Нэр томьёоны нийцэл	Тодруулах	4.1.15-ын нягтлах

4 Дотоод ба бусад хуультай нийцэл	Засах	23–29, 34, 46–47, 67 дугаар зүйлийн эшлэл нягтлах
5 Давхардал	Бууруулах	11–14-ийн хяналтын мэдээллийг солилцоно; 34 ба 67-ын нэг жилийн тайланг давхардуулахгүй.
6 Хэрэгжүүлэх этгээд	Ихэнх нь тодорхой	38.4-ийн шийдвэр гаргах этгээд ба 54-ийн гадаад төлөөллийн эрхийг тодруулна.
7 Орхигдсон харилцаа	Нөхөх	Батлагдаагүй мэдээллийн идэвхтэй төлөв, хадгалалтын ялгаа; хамтарсан хүлээн авах ажиллагаа.
8 Төрийн чиг үүргийн давхардал	Нягтлах	Цагдаа байгууллагын чиг үүргийг уялдааг нягтлах, зохицуулагч салбарын үүргийг хянах
9 Төрийн бус этгээдийн оролцоо	Боломжтой хэсгийг ялгах	Сургалт, техникийн дэмжлэгийг гэрээгээр хийж болно;
10 Татвар хураамж	Шинээр тогтоогоогүй	Иргэний мэдээлэл, хуулбар төлбөргүй.
11 Зөвшөөрөл	Нийцнэ	Одоогийн Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуультай нийцнэ
12 Үндсэн хууль гэрээ хүний эрх	Нийцнэ	Хамрах хүрээ, дүн, хугацаа, мэдээлэл, гомдлын хамгаалалтыг долоодугаар хэсэгт үнэлсэн.
13 Жендэр	Нийцнэ	Нийцэл хангагдсан
14 Шударга өрсөлдөөн	Нягтлах	30.6-ийн эрсдэлд тохирсон үүргийг бодитоор хэрэгжүүлнэ.
15 Авлига хүнд суртал	Байхгүй	Эрхийн үндэслэл, хандалтын лог, шийдвэрийн хугацаа, дахин хяналтыг бүртгэх зэрэг заалт бий
16 Хориг ба хариуцлага	Тодорхой	Тусгагдсан.

Ес. Зөвлөмж

9.1. Хадгалах зохицуулалт

3.7, 22.2, 32.4.6 дахь баримт дутуу үед мэдээлэл авах хамгаалалт; 19 дүгээр зүйлийн хүний хяналт; 23.4–23.6, 25.2 дахь хугацаа ба хөрөнгийн хэмжээг хязгаарлах баталгаа; 27.6, 29.3 дахь шалгалт хязгаарлалтыг сунгахгүй байх зааг; 28.1-ийн зөвшөөрөл ба шийдвэрийн үндэслэл; 57–61-ийн гомдол, шалтгаант холбоонд суурилсан хариуцлага; 63–65-ын хүртээмж, туслалцааг зохицуулсан заалт нь оновчтой тул хадгалах нь зүйтэй.

9.2. Сайжруулах заалтууд:

1) 3.2.1 дэх Монгол Улсаас техникийн хувьд нэвтрэх боломжийг бие даасан шалгуур болгохыг хасаж, Монголын зах зээлд чиглүүлсэн үйл ажиллагааг бодит шинжээр тогтооно. 3.5 дахь гэрээний маргааны хасалтыг залилангийн шинжгүй маргаанд хамааруулна. Эдгээр засвар нь хэрэгжүүлэгчийн хүрээг үндэслэлтэй болгож, хохирогчийн хамгаалалтыг буруу хасахаас сэргийлнэ.
2) тавдугаар хэсгийн эшлэл, дугаарлалтын алдааг засаж, дараа нь бүх 72 зүйлийн эшлэлийг дахин тулгар. 23–26 дугаар зүйлийн алдааг ердийн хэл найруулгын засвараас түрүүлж шийдвэрлэх шаардлагатай.

3) 17.6-д эрсдэлийн дохионы идэвхтэй хэрэглээ болон нотолгооны хадгалалтыг ялгаж, алдаатай мэдээлэл залруулах, устгах, дахин шалгах нөхцөлийг тодорхой болгох.
4) 30.6-ын зарчмыг 15.3, 32.4-ийн ажиллагаатай холбож, хамтарсан хүлээн авах суваг ашиглах боломжийг эрх бүхий шийдвэрийн зааг, нууцлал, хугацааны хариуцлагатай нь тодруулах.
5) 60.5-ын нөхцөлийг 32.3, 60.6-тай нийцүүлж, хохирогчийн үйлдэл хохиролд нөлөөлсөн хэмжээгээр хариуцлага хуваарилах зарчмыг тодруулах.

--oOo--